



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Захиргааны эрх зүйн маргаан)¹

1988 ОНЫ МЕЛЬБУРНЫ ОЛОН УЛСЫН ЦАХИЛГААН ХОЛБООНЫ ЖУРМЫГ ХЭРЭГЛЭХЭЭР ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДАЛ ТОГТООВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2026/0005

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулж, татварын нөхөн ногдуулалтын актыг түдгэлзүүлж, дахин шинээр акт үйлдэхийг хариуцагчид даалгасан анхан шатны шүүхийн шийдлийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Татварын хяналт шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагч нар харилцаа холбооны тусгай зөвшөөрөл бүхий нэхэмжлэгч хуулийн этгээдийн 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, нийт 354,993,070,667.26 төгрөгийн зөрчилд 77,349,961,133.73 төгрөг төлүүлэхээр нөхөн ногдуулалтын акт тогтоожээ.

Нэхэмжлэгч хуулийн этгээд энэхүү нөхөн ногдуулалтын актыг эс зөвшөөрч “... цахим орчинг үүсгэн байгуулах, харилцан холболт хийх, мэдээллийн транзит урсгалыг дамжин өнгөрүүлэх үйл ажиллагаа явуулдаг, харилцагч байгууллагууд манай байгууллагаас хүлээн авсан төлбөрөөс улсдаа татвар төлдөг, 2012 онд Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо хуралдсан Олон Улсын цахилгаан холбооны бага хурлаас баталсан Олон Улсын харилцаа холбооны журмыг баримталж төлбөр нэхэмжилсэн улсдаа төлнө, улс улсдаа тус тусдаа төлөхгүй, өөр өөрөөр төлөхгүй, харилцаа холбооны улс болгон нэгдсэн журамтай, харилцан ашигтай, хос сүлжээ хэрэглэж, интернетийн хямд, найдвартай үйлчилгээ хүргэх зорилгын хүрээнд татвар давхардахгүй байх тусгайлсан зохицуулалттай ...” гэж шүүхэд маргаан үүсгэжээ.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3453?daterange=2025-12-23%20-%202025-12-24&id=3&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2026.03.10).



Харин хариуцагчаас Монгол Улс соёрхон батлаагүй, албан ёсоор хэвлэн нийтлээгүй учир Дубайн журмыг хэрэглэхгүй, дотоодын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ. Давхар татварын гэрээний тухайд, тухайн улс орны оршин суугчийн сертификат авчирч давхар татварын асуудлыг шийдүүлэх ба хяналт шалгалтын хугацаанд ийм баримт өгөөгүй гэх үндэслэлүүдээр нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч маргасан.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүхээс:**² “2008 оны Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.2³ болон 2019 оны Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.2⁴-т тус тус заасны дагуу Монгол Улс Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотод 2012 онд хуралдсан Олон улсын цахилгааны холбооны байгууллагын бага хурлаас баталсан Төгсгөлийн баримт бичиг болох Олон улсын харилцаа холбооны журмыг хэрэглэх боломжтой бөгөөд мөн журмын 8.3.1 дэх заалтад заасан онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээ байгаа эсэхийг татварын хяналт шалгалтын явцад нотлох баримт цуглуулж, тогтоосны үндсэн дээр дахин шийдвэр гаргах шаардлагатай, үүнийг шүүхээс нөхөн гүйцэтгэх боломжгүй бөгөөд шүүхийн шинжлэн судлах хүрээнээс хэтэрсэн байна” гэж дүгнэн, дахин шинэ акт гаргахыг Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Татварын хяналт шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагч нарт даалгаж шийдвэрлэжээ.
- 2. Давж заалдах шатны шүүхээс:**⁵ “Нэгэнт хариуцагч Олон улсын харилцаа холбооны журмыг хэрэглэх боломжгүй гэсэн байр сууриа байнга илэрхийлсээр байхад “онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээ” байгаа эсэхийг хаанаас, ямар нотлох баримтыг цуглуулж тогтоосны үндсэн дээр дахин ямар шийдвэр гаргах нь ойлгомжгүй байх тул шүүхийн шийдвэр биелэгдэх боломжтой байх, хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй гэж үзэж, талуудын давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, анхан шатны шүүхийн шийдвэрт нөхөн ногдуулалтын актаар ногдуулсан төлбөрийн хэмжээг нийт 15,648,370,947.45 төгрөгөөр багасгасан өөрчлөлт оруулжээ.

Ингэхдээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төсөвт төлөөгүй гэх нийт 354,993,070,667.26 төгрөгийн зөрчилд 52,161,236,491.49 төгрөгийн нөхөн татвар, 9,540,353,694.79 төгрөгийн алданги төлүүлэхээр шийдвэрлэсэн

² Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/18836?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2026.03.10).

³ Татварын ерөнхий хууль (2008)-ийн 2 дугаар зүйлийн 2.2 “Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө”.

⁴ Татварын ерөнхий хууль (2019)-ийн 2 дугаар зүйлийн 2.2 “Монгол Улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө”.

⁵ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/9148?daterange=2025-01-01%20-%202026-03-10&id=2&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2026.03.10).



нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй. Харин тус актаар нийт 354,993,070,667.26 төгрөгийн зөрчилд 15,648,370,947.45 төгрөгийн торгууль оногдуулсныг давж заалдах шатны шүүх буруу гэж үзэж холбогдох төлбөрийг бууруулсан үндэслэлээ Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ 2019 оны 03 дугаар сарын 22-ний өдөр батлагдсантай уялдуулж Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлд мөн өдөр дээр дурдсан өөрчлөлт орсон бөгөөд эдгээр хуулийн зохицуулалтаас дүгнэхэд татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгч гэдэгт татвар суутгагчийг хамааруулахгүй гэж тайлбарласан.

3. **Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нараас:**

“Маргаанд Олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх эсэх талаар анхан болон давж заалдах шатны шүүхүүд зөрүүтэй дүгнэлт хийсэн. Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоо дагаж мөрдөх үүрэгтэй, түүнийг захиргааны байгууллага үйл ажиллагаандаа мөрдөнө, үгүй гэхэд шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэх байсан. Монгол Улс конвенц, дүрэмд нэгдэн орсон, түүнийг соёрхон баталсан байтал давж заалдах шатны шүүхээс тухайн үйл баримт, гэрээ, конвенц, Олон Улсын гэрээний тухай хууль, Улсын дээд шүүхийн тогтоолыг маш явцуу байдлаар, буруу тайлбарлан хэрэглэсэн нь хууль хэрэглээний зөрүү үүсгэж байна.

Цахилгаан холбоо, интернэтийн сүлжээ нь дэлхий нийтийг хамарсан, улс болгон хоорондоо холбогдож байж оршин тогтнодог онцлогтой, өнөөгийн дэлхий ертөнцийг бүх хэсэгт хором мөн бүрт ашиглагдаж байгаа салбар бөгөөд түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт хэм хэмжээ асар их байх нь ойлгомжтой. Гэхдээ улс орон бүр өөр өөрсдийн салангид дүрмийг тогтоох боломжгүй, харилцан хамааралтай, нэгдсэн гэж хэлж болохуйц дүрэм журам шаардагдана. Татварын харилцаа ч адил буюу Монгол Улс дэлхийн дүрмээс өөр дүрэмтэй байх боломжгүй. Өөрөөр хэлбэл эрх зүйн шинэ ойлголт, хууль хэрэглээг тогтоох зарчмын ач холбогдолтой” [гэх үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргажээ.](#)

4. **Хяналтын шатны шүүхээс:** Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж, Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Улсын Их Хурал дараах олон улсын гэрээг заавал соёрхон батална”, 8.1.5-д “чөлөөт худалдаа, давхар татвар, хөрөнгө оруулалттай холбогдсон олон улсын гэрээ” гэж заасныг маргааны үйл баримтад холбогдуулан тайлбарлахад татварын маргаанд Улсын Их Хурлаас соёрхон баталсан олон улсын гэрээг хэрэглэх зохицуулалттай бөгөөд энэ тохиолдолд 2012 онд Дубай хотноо баталсан Олон улсын харилцаа холбооны журмыг шүүх энэхүү маргаанд хэрэглэхгүй. (13)⁶

5. Олон улсын цахилгаан холбооны журам нь анх 1988 оны Мельбурны бага хурлаар батлагдсан бөгөөд Монгол Улс 1994 он, 2003 он, 2015 онд Олон улсын цахилгаан холбооны байгууллагын дүрэм, конвенци, нэмэлт

⁶ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



- өөрчлөлтийг соёрхон батлахдаа уг журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн байх тул энэ тохиолдолд 1988 оны Мельбурны журмыг маргааны үйл баримтад хэрэглэх үндэслэлтэй байна. (15)
6. Энэ тохиолдолд маргааны гол үйл баримт болох интернэт урсгалын төлбөр, сервер байршуулсны төлбөр, засвар үйлчилгээний төлбөр, сувгийн түрээсийн төлбөр, апплейкшн ашигласны төлбөр, гишүүнчлэлийн төлбөр зэрэг нь олон улсын цахилгаан холбооны үйлчилгээний төлбөр хураамжид хамаарах эсэх, онцгой нөхцөлөөс шалтгаалан өөрөөр хэлэлцэн зохицуулсан эсэх, онцгой нөхцөл байдал гэдэгт юуг ойлгох, “татварыг зөвхөн тухайн улсын хэрэглэгчдэд үзүүлсэн олон улсын үйлчилгээнд ногдуулна” гэсэн нь ямар агуулгатай болох, хэрэглэгчийн хүрээ, “тухайн эрх бүхий үйл ажиллагаа эрхлэгчийн дансны тарифын хувь хэмжээ эсхүл бусад орлогод санхүүгийн татвар ногдуулсан бол, бусад эрх бүхий үйл ажиллагаа эрхлэгчид энэ санхүүгийн татварыг төлөх үүрэг хүлээхгүй” тухай зохицуулалт маргааны үйл баримтад хэрхэн хэрэглэгдэхийг татварын алба шинжлэн судлах шаардлагатай. (20)
7. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх арга журмын тухайд, татварын улсын байцаагч нараас 1988 оны Мельбурны Олон улсын цахилгаан холбооны журам, түүний хавсралтыг Гадаад хэргийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас мэргэжлийн туслалцаа авч, баталгаат орчуулга хийлгэж, нэхэмжлэгч хуулийн этгээдийн шилжүүлсэн төлбөр бүрт хамаарах эрх зүйн дүгнэлтийг хийж, суутгагчийн үүрэгтэй эсэх талаар 6 сарын дотор шинжлэн судалж, төлбөр тогтоох эсэхийг шийдвэрлэх замаар шүүхийн шийдвэрийг биелүүлнэ. (25)
8. Дээрх үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, нөхөн ногдуулалтын актын 3 болон 4 дэх хэсэг буюу “гадаадын аж ахуйн нэгжид орлого олгохдоо аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвар суутган авч, төсөвт төлөөгүй” гэх хэсгийг түдгэлзүүлж, дахин шинээр акт үйлдэхийг хариуцагч нарт даалгаж шийдвэрлэсэн бөгөөд харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх “А” ангиллын тусгай зөвшөөрөлтэй, нэхэмжлэгч хуулийн этгээдийн татварын харилцаанд олон улсын гэрээний холбогдох зохицуулалт хэрэглэгдэх агуулгаар хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоожээ. (26, 27)

Хураангуй бэлтгэсэн: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Г.Урангуа